

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН  
ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР

2020 ОНЫ ГУРАВДУГААР САРЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 03 дугаар сарын 31

Дорнод аймаг

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, А/75 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам” болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэ хугацаанд ОХУ-ын гарцтай Ульхан, Эрээнцав, боомтууд Улсын онцгой комиссын тогтоосон хязгаарлалтын дагуу ажилласан. БНХАУ-ын гарцтай авто замын Баянхошуу, Бичигт, Хавирга боомт Засгийн газрын 2020 оны 39 дугаар тогтоолын дагуу түр хаасан. Улсын онцгой комиссын 6 тогтоолын дагуу ахлах нягтлан бодогч Х.Хэрлэн-Урсгал, мэргэжилтэн Г.Намуунзаяа нар цахимаар ажил гүйцэтгэж байна. Тус хугацаанд 3 албан хаагч 2020 оны ээлжийн амралтаа биеэр эдэлж, Байгууллагын даргын 2020 оны Б/30 тоот тушаалаар Захиргааны ахлах мэргэжилтэн С.Мөнхжаргал, Б/31 тоот тушаалаар мэргэжилтэн Х.Тайванбаатар нар өөрийн хүсэлтээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн.

Нэг. Захиргаа, удирдлага

Байгууллагын даргын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар Сүхбаатар аймаг дахь ахлах мэргэжилтэн Ц.Солонгыг Гадаадын иргэн, харьяатын газрын мэдээллийн төвийн ахлах мэргэжилтэнгээр, 03 дугаар сарын 20-ны өдрийн Б/63 дугаар тушаалаар хяналтын улсын байцаагч Г.Хосбаатарыг Хяналт шалгалтын газарт хяналтын улсын байцаагчаар тус тус томилсон.

Мөн оны 03 дугаар сарын 24-ны Б/69 дугаар тушаалаар хяналтын улсын байцаагч Д.Мөнхбаярыг 3 сарын хугацаатай цалингийн 10 хувь бууруулах сахилгын шийтгэл, 03 дугаар сарын 25-ны өдрийн Б/71 тоот тушаалаар хяналтын улсын байцаагч Д.Дэлэгт сануулах сахилгын шийтгэлийг тус тус ногдуулсан. Өгсөн үүрэг даалгавар хангалтгүй биелүүлсэн жижүүр Ш.Болдын ёс зүйн талонд сануулах арга хэмжээ авсан.

Хяналтын улсын байцаагчийн сургалтанд хамрагдах 2 албан хаагчийн судалгаа, боомтод ажилласан албан хаагчдын судалгааг төвд хүргүүлсэн.

Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст Бүсийн газрын 03 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, 3 дугаар сарын төлөвлөгөөний биелэлт, инфо мэдээ, 04 дүгээр сард хийх ажлын төлөвлөгөө тус тус хүргүүлсэн.

Уулзалт, зөвлөгөөн, хамтын ажиллагаа. Даваа гараг бүрийн өглөө 8 цагт зохион байгуулагддаг Дорнод аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд дарга, хяналтын улсын ахлах байцаагч нар сууж орон нутгийн талаарх мэдээ мэдээллийг авч ажиллаж байна.

Аймгийн онцгой комиссын шуурхай хуралдаанд Бүсийн дарга, хяналтын улсын ахлах байцаагч нар сууж хуралдаанаас гарч буй шийдвэрийг хэрэгжүүлэн албан хаагчдад танилцуулан биелэлтийг хангаж ажилласан.

Аймгийн онцгой комиссын шийдвэрээр 2020 оны 02 дугаар сарын 29-нөөс 03 дугаар сарын 02-ны өдрүүдэд Ульхан, Эрээнцав боомтын өндөржүүлсэн бэлэн байдлыг шалгах ажил ажлын хэсэг байгуулагдаж, хяналтын улсын ахлах байцаагч тус боомтуудад ажилласан.

Дорнод аймгийн Матад сумын нутаг дэвсгэрт газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг”ХХК-ийн тээвэрлэлтийн ажлыг эхлүүлэх болсонтой холбогдуулан бэлэн байдлыг хэрхэн хангасан талаар газар дээр нь шалгах ажил Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин тэргүүтэй ажлын хэсэг Баянхошуу боомтод ажилласан.

Аймгаас томилогдсон ажлын хэсгийн хамт хяналтын улсын ахлах байцаагч боомтод ажиллаж, “Тусгаарлах байр”-ыг өөрчлөх санал тавьсаны дагуу Баянхошуу боомтын ажлын өрөөг Мэргэжлийн хяналтын газарт түр хугацаагаар хүлээлгэн өгч, Мэргэжлийн хяналтын байранд ажлын өрөөг шилжүүлэн оруулсан.

Бүсийн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/01 дугаартай баталсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах хуваарь”-ын дагуу Дорнод аймгаас орох, гарах гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих болон зорчигчдын эрүүл мэндэд хяналт тавих, тандалт үзлэг хийх, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж албан хаагчид эргүүлийн үүрэг гүйцэтгэн үр дүнг илтгэх хуудсаар Бүсийн даргад танилцуулан ажиллаж байна.

Сургалтад хамрагдсан талаар: Зүүн бүс дэх газар болон Дорнод аймгийн Цагдаагийн газрын даргын хамтран баталсан 2020 онд “Хамтран ажиллах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын төлөвлөгөө”-ний 8 дахь заалтын хангах зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр тус газрын цагдаагийн ахмад А.Гантулгын “Гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх” тухай сэдэвт сургалтад албан хаагчид хамрагдсан.

Дорнод аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн Тасгийн дарга хошууч П.Ганхуяг замын хөдөлгөөний аюулгүй байдал, замын хөдөлгөөнд оролцоход анхаарах асуудал сэдвээр сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд бүсийн төвд ажиллаж буй 10-н албан хаагч оролцов.

Бичиг хэргийн эргэлтийн талаар: Ирсэн бичиг: Байгууллагын удирдлагаас 5, бусад байгууллагаас 8, нийт 13-н албан бичиг ирж, үүнээс хариутай 2 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг хүргүүлсэн.

Явсан бичиг: Ажлын зохион байгуулалттай холбоотойгоор байгууллагын удирдах албан тушаалтанд явуулсан албан бичиг 1, бусад байгууллагад 26 албан бичиг үйлдэж холбогдох байгууллагуудад явуулж мэдээ мэдээлэл солилцон ажилласан байна.

Өргөдөл: Тус сард албан хаагчдаас 1 өргөдөл хүсэлт хүлээн авч төвд хүргүүлэн ажилласан. Ажилд орох хүсэлт гаргасан өргөдөлийг хүлээн авч төвд шилжүүлсэн.

Монгол улсын иргэн Т.Анхбаяраас ирүүлсэн өргөдлийг хүлээн авч хариуг утсаар мэдэгдэн ажилласан.

Санхүүгийн талаар: 2020 оны 03 дугаар сард 53,926,400.00 төгрөгийн санхүүжилтийг авснаас 29,821,324.09 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн.

2020 оны 02 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 126,957,600.00 төгрөгийн санхүүжилт, 73,510,07.63 төгрөгийн гүйцэтгэлтэй, 53,447,502.37 төгрөгийн үлдэгдэлтэй гарсаныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хангалт, үйлчилгээний газарт хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны 02 дугаар сарын тайлангаар улсын тэмдэгтийн хураамж орлогод 0.00 төгрөг, хүү, торгуулийн орлогод 0.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Цалин хөлсний нийгмийн даатгалын 02 дугаар сарын тайлангаар нь нийт 27 албан хаагчдын 27,357,707.41 цалин, ногдол 6,276,706.61 төгрөг гарсаныг нийгмийн даатгалын санд шилжүүлж, цахимаар шивж цаасаар баталгаажуулсан.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж шинэчлэгдсэн сайтанд 2020 оны 02 дугаар сарын мэдээллийг хуулийн хугацаанд шивж дуусгасан.

Сар бүр санхүүгийн ил тод байдлын самбарын мэдээллийг шинэчлэн албан хаагчдыг санхүүгийн мэдээллээр ханган ажиллаж байна.

Эд, хөрөнгө, хангалтын талаар: Бараа материалын тайланг сарын 30-ны өдрөөр тасалбар болгон Нийтийн аж ахуй, “ДБЭХС”, “Цахилгаан холбоо”, “Монгол шуудан”, “Мэдээлэл холбоо”, “НИК”, ХХК -тай тулгалтыг хийж тооцоо нийлсэн акт үйлдэн ажиллаа. Мөн Бүсийн газрын автомашины зам/км, шатахуун, бараа материалын тооцоог гаргаж ахлах нягтлан бодогчид тайлагнасан.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар хавсралтын 4.5.6-д заасны дагуу албан хаагч нар ажил үүргээ гүйцэтгэхэд бичиг хэргийн хэрэгслээр хангаж ажилласан. Бичгийн цаас 30 боодлыг 329,970 төгрөгөнд худалдан аваад байна.

Ажлын болон амьдрах байраны өрөө тасалгаа, ариун цэврийг сахин мөрдүүлж, ариутгалын бодис болон цэвэрлэгээний бодисуудаар ханган ажилласан. Чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийлгэж байна. Ариутгал цэвэрлэгээний 151 ширхэг бодис материалыг 497520 төгрөгөнд худалдан аваад байна.

Албан хаагч нар ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах дүрэмт хувцас, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангагдсан.

2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар хавсралтын 35-д заасны дагуу Бүсийн газрын албан хаагчдын эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих үүднээс витаминжуулах аяныг өдөр бүр тогтмол зохион байгуулж чацаргана, нэрс, аньс зэргийг тогтмол уулгаж байна.

“Корона” вирусээс урьдчилан сэргийлэхийн тулд төвөөс хамгаалалтын иж бүрэн хувцас 5 ширхэг, спирт 5 литр, маск 72 ширхэг, халууны шил 1 ширхэг, халуун хэмжигч 3 ширхэг, нэг удаагийн бээлий 100 ширхэг, бүсийн төвөөс 70 ширхэг маск 77840 төгрөгөнд худалдан авч нөөцлөөд байна.

Албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт, шаардах хуудасны дагуу 36 нэр төрлийн бараа материалыг 1,179,500 төгрөгөнд худалдан авч холбогдох албан тушаалтан нарт шаардах хуудасны дагуу олгосон.

Хангалт үйлчилгээний чиглэлээр: Албаны 65-99 ДОР улсын дугаартай “Тоёота приус” 74-39 ДОО улсын дугаартай “УАЗ ФУРГАН” автомашины аюулгүй байдал, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж 289000 төгрөгөнд наклад, тос тосолгооны материал худалдан авч техник үйлчилгээг хийлгэсэн.

Мэдээлэл, технологийн чиглэлээр: Тайлангийн хугацаанд Бүсийн газар болон харьяа хилийн боомтуудын сүлжээнд хяналт тавьж ажилласан. Тус хугацаанд Ульхан боомтын дотоод сүлжээ тасалдахад шуурхай арга хэмжээ авч засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан.

Хилийн боомтод хуваарийн дагуу ажиллаж байгаа хяналтын улсын байцаагч Г.Хосбаатарын “ISM” системийн шилжүүлэх эрхийг бүртгэн авч, хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст танилцуулан тус програмын эрхийг шилжүүлсэн.

Хилийн боомтуудын дотоод сүлжээнд ашиглагдаж байгаа 9 ширхэг компьютерт Eset endpoint security антивирусны програмын лицензийг сунгаж 03 дугаар сарын антивирусны програмын шинэчлэлтийг хийж ажилласан.

Хилийн боомтуудыг камержуулах, тус камерыг бүсийн газарт хянах зорилгоор интернэт сүлжээг нэвтрүүлэх шаардлагатай байгаа тул сүлжээний дэд бүтэц, зардлын тооцоог судлаж дарга Б.Тамирт илтгэх хуудсаар танилцуулсан.

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/79 тушаалын дагуу “Гадаадын иргэн, харьяатын газрын Зүүн бүс дэх газар” нэртэй фэйсбүүк хуудсыг устгаж, мөн бүсийн газрын 14 албан хаагч нарт тус тушаалыг танилцуулан баталгааны хуудсыг авч дарга Б.Тамирт илтгэх хуудсаар танилцуулсан.

Газрын дарга Б.Тамирын албанд ашиглаж байсан Dell “INSPIRON N5010” маркийн зөөврийн компьютерийн хард диск доргилтийн улмаас гэмтэж эвдэрсэн тул хард дискийг сольж засварлаж, хүлээлгэн өгсөн.

03 дугаар сарын 23-ны өдөр бүсийн газрын интернэтийн гэрээг цуцлах талаар “Монголын цахилгаан холбоо” ХК-ны Дорнод аймаг дахь салбарт албан тоотоор мэдэгдэж, гэрээг цуцласан.

Төрийн албаны ил тод, нээлттэй байх, иргэдийг мэдээллээр хангах эрхийн дагуу [www.immigration.gov.mn](http://www.immigration.gov.mn) сайтын “Боомт орон нутаг” цэсэд 02 дугаар сарын тайлан, төлөвлөгөөний биелэлт, 03 дугаар сарын төлөвлөгөөг шинэчлэн оруулсан.

Хилийн боомтуудын хяналтын улсын байцаагч болон мэргэжилтэн нарт сүлжээ, “ISM” систем болон компьютер техникийн 4 удаагийн зөвлөгөө өгч ажилласан.

#### Хоёр. Виз, зөвшөөрлийн чиглэлээр

Хариуцсан хилийн боомтуудаар ОХУ-ын 38 гадаадын иргэн улсын хилээр нэвтэрснээс орох чиглэлд 19, гарах чиглэлд 19 гадаадын иргэн нэвтэрсэн байна.

Тайлант хугацаанд бүсийн хэмжээнд виз олгогдоогүй болно.

Виз сунгалт: БНХАУ-ын 1 иргэнд зохих журмын дагуу визийг 30 хоног сунгасан.

Алдаатай визийн бүртгэл: байхгүй

Түр ирэгчийн бүртгэл -3, хасалт-3

Оршин суух зөвшөөрлийн хасалт: байхгүй

ХОНДЗҮ-ээр хил нэвтэрсэн зорчигч байхгүй

Хурууны хээ: Тайланд хугацаанд хурууний хээ аваагүй

Хувийн урилга: Тайлант хугацаанд хувийн урилга олгоогүй.

Зөвөлгөө мэдээлэл: 40

- Бичигт боомтод БНХАУ-ын 1 иргэний албан хүсэлтийг үндэслэн визийн сунгалт хийсэн.

- Ульхан боомтод ОХУ-ын 11 иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, виз, визийн ангилал төрөл, зориулалтын талаар;

- Эрээнцав боомтод ОХУ-ын 27 иргэнд;

- Бүсийн төвд 2 иргэн, аж ахуйн нэгжид виз, визийн ангилал, түр ирэгчийн талаар зөвлөгөө өгсөн.

Ярилцлага хийсэн бүртгэл: 2

- Хилийн боомтуудад ОХУ-ын 19 иргэний виз Монгол Улсад зорчих зорилготой нийцсэн эсэх талаар ярилцлага хийн тэмдэглэл хөтөлсөн. Үүнд: Ульхан боомтод 6, Эрээнцав боомтод 13 иргэнтэй ярилцлага хийсэн.

Баталгаа гаргасан: Байхгүй

Сүлжээний хяналт: ОХУ-д гарцтай Ульхан, Эрээнцав авто замын боомтуудад хилээр зорчсон 1 орны 38 иргэний хөдөлгөөнд хяналт тавьж, 8 гадаадын иргэний мэдээллийг "ISM" сүлжээнд шалган нэвтрүүлсэн.

#### Гурав. Хяналт шалгалтын чиглэлээр

Тус газар нь гуравдугаар сарын тайлангийн хугацаанд Бүсийн газрын даргын баталсан №12/05-2020/05 дугаар удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт 1, Хэнтий аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус 1, нийт 2 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт хяналт шалгалтанд 2 аж ахуй, нэгжийн гадаадын 18 /БНХАУ-ын 18 / иргэн хамрагдаж, шалгалтанд хамрагдсан аж ахуй нэгжийн удирдлага болон гадаадын 5 иргэнд зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтаар илэрсэн зөрчилгүй.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтанд 5 аж ахуй нэгж хамрагдсан. Шалгалтанд хамрагдсан гадаадын иргэн байхгүй байсан.

Тайлангийн хугацаанд Бүсийн хэмжээнд 4 зөрчлийг илрүүлж, 1 аж ахуй нэгжийн 1 иргэнд 210,000.00 /хоёр зуун арван мянга/-н төгрөг, хувь хүнээр 3 иргэнд 210,000.00 /хоёр зуун арван мянга/-н төгрөг нийт 420.000.00 /дөрвөн зуун хорин мянга/-н төгрөгийн торгууль ногдуулж ажилласан.

Хил дээрээс буцаагдсан иргэдийн талаар: Байхгүй.

Албадан гаргалтын талаар: Байхгүй.

Албан шаардлага хүргүүлж ажилласан талаар: Албан шаардлага хүргүүлсэн аж ахуй нэгж байхгүй.

Дэлхийн хэмжээнд дэгдээд буй коронавирусын дэгдэлттэй холбоотойгоор авч буй арга хэмжээний хүрээнд гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор эргүүлийн хуваарь батлуулан авто замын пост, агаарын болон төмөр

зам, хот хоорондын зорчигч тээврийн газруудад хяналт шалгалтыг хийж үр дүнг илтгэх хуудсаар Бүсийн даргад өдөр бүр танилцуулж ажиллаж байна.

Гадаадын иргэдийг бүртгэлээр хянах зорилгоор Дорнод аймгийн 14-н сумын Засаг дарга, аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй 8-н зочид буудалд албан бичиг хүргүүлж, харилцан мэдээлэл солилцон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан.

Байгууллагын даргын “Албан даалгавар”-ын биелэлтийг тухай бүр гарган төвд хүргүүлэн ажиллаж байна.

ТАНИЛЦСАН.

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,  
ДОТООД АУДИТ, ОРОН  
НУТГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАТСҮХ

ХЯНАСАН.  
ДАРГА

Б.ТАМИР

ТАЙЛАН БИЧСЭН.  
ХЯНАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

Б.ЭРДЭНЭТУЯА